



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/822

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 8.1.5 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн агаар бохирдуулагчдын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг хийж, дүн мэдээг нэгтгэн, цахим санд байршуулах, цаашид авах арга хэмжээг төлөвлөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн дарга: - Т.Жаргалсайхан -Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: - Ц.Ганданповрон -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Л.Батбаяр -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
 - П.Эрдэнэчулуун -Мэргэжлийн хяналтын газрын дарга
 - Р.Энхсүрэн – Хар нуур, Ховд голын сав газрын дарга
 - С.Батмөнх – Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга
 - Б.Алтанбадралт – Аймгийн онцгой байдлын газрын дарга
 - Ц.Мягмарсүрэн -Эрүүл мэндийн газрын дарга
 - Х.Батцэцэг – Аймгийн татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
 - Н.Ирэхзаяа – Аймгийн авто тээврийн газрын дарга
 - Х.Баасанхүү - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

- А.Цэен-Ойдов – Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
- С.Жавзанпагма – Ус цаг уур орчны шинжилгээний төвийн лабораторийн эрхлэгч
-
- Сумдын Засаг дарга нар
-

Нарийн бичгийн дарга: - А.Энхзаяа – Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Дарга

2. Хариуцан авсан албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийн тооллогыг батлагдсан маягтын дагуу хийж гүйцэтгэн дүнг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны дотор Ус цаг уур, орчны шинжилгээний төвд ирүүлэхийг ажлын хэсэгт багтсан холбогдох байгууллагын дарга нар, Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Тооллогын дүнг нэгтгэн цахим санд бүртгэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газарт 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдөрт багтаан хүргүүлэхийг Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /А.Энхзаяа/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ